Нийт хөрөнгийн дүн	2,440,653.5	1,669,602.3	(771,051.2)
Богино хугацаат өр төлбөр	700,000.0	1,621,418.6	921,418.6
Засгийн газрын хувь оролцоо	1,740,653.5	48,183.7	(1,692,469.8)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,440,653.5	1,669,602.3	(771,051.2)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 140.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны арилжааны банкны дансны үлдэгдлийг төсөвт төвлөрүүлснээс шалтгаалжээ.
- Авлагын дансны үлдэгдэл 164,974.8 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 397,822.2 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй 5,074.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны 265,403.4 мянган төгрөгийн үлдэгдлийг тус тус төсөвт татан төвлөрүүлж, 416,867.8 мянган төгрөгийг авлагаар бүртгэснээс шалтгаалжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 261,701.3 мянган төгрөгөөр буурсан нь 385,374.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 647,075.9 мянган төгрөгийн бараа материалыг албан хэрэгцээнд зарцуулснаас шалтгаалжээ.

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 674,184.4 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 772 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 398 нэр төрлийн 2,201,093.2 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 59 нэр төрлийн 237,171.1 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг 47,434.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, төсвийн хөрөнгөөр 18,500.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж шинээр худалдан авч, тайлант хугацаанд 735,749.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулж, 4,369.2 мянган төгрөгийн ашиглах хугацаа дууссан хөрөнгөд элэгдэл байгуулаагүйгээс өмнөх үеийн үр дүнд залруулга хийснээс шалтгаалжээ.
- Богино хугацаат өр төлбөр 921,418.6 мянган төгрөгөөр өссөн нь Элсэлтийн шалгалт болон Монгол хэл бичгийн шалгалтын зардлын 916,344.0 мянган төгрөгийн улсын төсвийн санхүүжилт олгогдоогүй, нэр данс зөрүүтэй 5,074.6 мянган төгрөгөөс тус тус шалтгаалжээ.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 1,692,469.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

Судалгааны үр дүн:

Боловсролын үнэлгээний төвийн нягтлан бодох бүртгэлд 10 нэр төрлийн нийт 1,114,438.5 мянган төгрөгийн программыг ашиглаж ашиглаж байгаа ба дэлгэрэнгүй судалгааг Д301/04 дүгээр маягтаар баталгаажуулж, баримтжуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 13,295,242.2 мянган тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 7,926,025.3 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 893,044.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 316,316.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 66,256.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 48,598.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 20,183.8 мянган, нормативд зардлыг 284.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж, урсгал шилжүүлгийг 239.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,167,362.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь 2025 төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 2025 оны 4 дүгээр сард 6,13,286.9 мянган төгрөгөөр 8 дугаар сард 38,359.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 12 дугаар сард 429,681.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,216,169.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,754,000.0 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,401,614.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсөвт байгууллагын өөрийн 2,153,041.6 мянган төгрөгийн орлого олж, 7,156,833.5 мянган төгрөгийг зарцуулж, 397,822.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,156,833.5 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 202,461.7 мянган, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлын төсвийг 610,872.3 мянган, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын төсвийг 0.2 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал 71808-80101	2,418,047.8	2,215,586.1	202,461.7	91.6
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 71808-81834	27,301.8	27,300.0	1.8	100.0
3	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 71808-80802	5,524,819.6	4,913,947.4	610,872.2	88.9
НИЙТ		7,970,169.2	7,156,833.5	813,335.7	89.8

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

1. Боловсролын сайдын 2023 оны А/594 дүгээр тушаалаар 71 орон тоотой ажиллахаар дээд хязгаарыг тогтоож, 2025 оны А/603 дугаар тушаалаар орон тооны дээд хязгаарыг 55 болгон бууруулж баталсан байна. Гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 49, нийт 50 орон тоотойгоор ажилласан байна.
2. Шалгагдагч байгууллагын 2025 оны А/14 дүгээр тушаалаар албан хаагчдын хоол унааны нэмэгдлийг ажлын нэг өдөрт 33.0 мянган төгрөгөөр тооцож баталсан байна. Үүнд: албан хаагчид ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлтийг 30.0 мянган, унааны зардлыг 3.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд хоол унааны хөнгөлөлтөд нийт 333,683.3 мянган төгрөгийг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 331,730.3 мянган төгрөг байна.
3. Тайланд хугацаанд гадаад томилолт, гадаад зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.
4. Тайланд хугацаанд сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зардлыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.
5. Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх шалгуулагч нарт зориулсан хөтөлбөрийг шалгуулагч нарт таниулахаар Төв хөгжлийн цацрах гэрэл төв ТББ-тай 4,900.0 мянган, Оюунлаг эргэлт медиа групп ХХК-тай 4,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.
6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 265,403.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлснийг төсөвт татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шалгагдагч байгууллагын захирлын 2025 оны А/05 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 350,000.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 762,900.0 мянган төгрөг, нийт 1,112,900.0 мянган төгрөгийн 13 худалдан авалт хийхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр www.tender.gov.mn худалдан авах ажиллагааны цахим системээр харьцуулалтын аргаар 295,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 худалдан авалтыг зохион байгуулж, 4 аж ахуйн нэгж байгууллагатай 279,279.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Боловсролын үнэлгээний төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардал 7,738,241.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 77,382.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн шилэн данстай холбоотой 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна"; 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"; 6.8-д "Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, шилэн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 413,150.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

- Шалгагдагч байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 27 нэр төрлийн нийт 1,469,153.3 мянган төгрөгийн хөрөнгөд хяналтын, түүвэрчилсэн тооллого хийж гүйцэтгэхэд 13,750.0 мянган төгрөгийн хөрөнгийг эд хариуцагч бүрээр хөрөнгийн карт хөтлөөгүй, хөрөнгө тус бүрийг кодолж бүртгээгүй;
- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын НХМаягт БМ-5 дугаар маягыг хөтлөөгүй;
- Ажиллагсад олгосон цалингийн урьдчилгаа 399,400.0 мянган төгрөгийг цалингийн урьдчилгаа /авлага/ дансанд бичилт хийхгүйгээр цалингийн өглөг дансанд бүртгэсэн;

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн 29,577.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 5,911.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 102,744.7 мянган төгрөгийн 3 албан шаардлагын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,911.5	1	5,911.5	100.0
Албан шаардлага	3	102,744.7	3	12,744.7	100.0
Зөвлөмж	3	29,577.6	3	29,577.6	100.0
Нийт дүн	7	138,233.8	7	138,233.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэх. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын шинэчлэн баталсан заавар журмуудад нийцүүлэн шинэчлэн баталсан байдлыг үзэх;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,361,907.8 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,361,907.8 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 587,838.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулаагүй;
- Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд нийгмийн даатгалын шимтгэлийн 460.5 мянган төгрөгийг сөрөг утгатай бүртгэсэн;
- Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын А/3 дугаар тушаалын дагуу иж бүрэн тайлагнаагүй;
- Байгууллага болон хувь хүнд төлөх 773,608.4 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 8,550.0 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд, 680.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 7,870.0 мянган төгрөгийн зөрчилд албан 1 шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 8,550.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 77,382.4 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төв аймагт ажилласан албан томилолтын тооцоог бодохдоо ирсэн явсан хоногийг 1 хоногоор тооцоогүйгээс 4 ажилтанд нийт 680.0 мянган төгрөгийн томилолтыг зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтыг илүү тооцсон 680.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Ажилласан хоногийг тэмдэглээгүй албан томилолтын хуудсаар 13 ажилтанд 7,870.0 мянган төгрөгийн албан томилолтын олговрыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог

Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын хуудсыг бүрэн хөтлөхгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 587,838.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулаагүй	1	587,838.9	-	-	1	587,838.9	1	587,838.9	-	-	-	-
2	Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд нийгмийн даатгалын шимтгэлийн 460.5 мянган төгрөгийг сөрөг утгатай бүртгэсэн;	1	460.5	-	-	1	460.5	1	460.5	-	-	-	-
3	Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын А/З дугаар тушаалын дагуу иж бүрэн тайлагнаагүй	1	-			1	-	1	-				
4	Байгууллага болон хувь хүнд төлөх 773,608.4 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүйг тус тус залруулсан.	1	773,608.4	1	773,608.4	-	-	1	773,608.4	-	-	-	-
	Дүн	4	1,361,907.8	1	773,608.4	3	588,299.40	4	1,361,907.8	-	-	-	-

Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								/мянган төгрөгөөр/	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Албан томилолтын тооцоог бодохдоо ирсэн явсан хоногийг 1 өдрөөр тооцоогүйгээс 4 ажилтанд нийт 680.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон байна.	1	680.0	1	680.0	-	-	-	-	-	-	-	-
2	Ажилласан хоногийг тэмдэглээгүй албан томилолтын хуудсаар 13 ажилтанд 7,870.0 мянган төгрөгийн албан томилолтын олговрыг олгосон байна.	1	7,870.0	-	-	1	7,870.0	-	-	-	-	-	-
	Дүн	2	8,550.0	1	680.0	1	7,870.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
				Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	-	-	-	1	-
Дүн		1	-	-	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 105/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/45/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймагт ажилласан албан томилолтын тооцоог бодохдоо ирсэн явсан хоногийг 1 хоногоор тооцоогүйгээс 4 ажилтанд нийт 680,000.00 /Зургаан зуун наян мянган/ төгрөгийн томилолтыг зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 680,000.00 /Зургаан зуун наян мянган/ төгрөгийн томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Э.Цэрэнцоодол/, ахлах нягтлан бодогч /У.Мөнхзул/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХЭЛЭГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: AKI/2026/0225-SAG-57.Docx

1526160575



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 507/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/45/КА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын үнэлгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилласан хоногийг тэмдэглээгүй албан томилолтын хуудсаар 13 ажилтанд 7,870,000.00 /Долоон сая найман зуун далан мянган/ албан томилолтын олговрыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандартад, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан томилолтын хуудсыг бүрэн хөтөлдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Э.Цэрэнцоодол/, ахлах нягтлан бодогч /У.Мөнхзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga\2026\0125 SAG-86.Docx

1526191042